



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А181

Ховд

Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн
бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.24, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.3, 11.4.2, 11.6, 11.8, 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 216 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам"-ын 4.1.1, 4.1.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээний 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнд хууль, эрх зүйн мэдлэг олгох онолын сургалтыг Цэргийн штабын сургалтын төлөвлөгөөний дагуу Алтай, Булган, Дарви, Зэрэг, Мөнххайрхан, Мөст, Үенч, Цэцэг сумдад 2024 оны 04 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.


2. Томилгоот нэгжийн сургалтыг зохион байгуулах бэлтгэлийг сайтар хангаж томилгоот нэгжийн бие бүрэлдэхүүнийг тогтоосон хугацаанд бэлэн байлгаж сургалтад хамруулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Сургалт удирдан зохион байгуулж явуулах бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сургалтын хөтөлбөр, сумдад ажиллах хуваарийг хоёрдугаар, сургалтад шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Сургалт зохион байгуулахад шаардагдах 2,881,160 (хоёр сая найман зуун наян нэгэн мянга нэг зуун жар) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэдийн орлогоос гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

5. Сургалт зохион байгуулж явуулсан тухай тайланг Батлан хамгаалах яаманд хүргүүлэхийг Цэргийн штабын дарга (хурандаа Б.Ганхуяг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 02391
Zah A/181 Ba